

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл нь 2 бүлэг, 6 зүйлтэй бөгөөд нэгдүгээр бүлэгт эрүүл мэндийн даатгалын сангийн хуулийн зорилтыг тусгасан бол хоёрдугаар бүлэгт эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төвлөрүүлэх орлогын хэмжээ, зарцуулах зарлагын хэмжээ болон эргэн төлөх төлбөрийн хэмжээг тус тус тусгасан.

Монгол Улсын Засгийн газар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, даатгуулагчийг өвчлөхөөс өмнө урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулах зорилтыг хангах хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын төсвийг гүйцэтгэлд суурилсан хэлбэрээр санхүүжүүлэх шинэчлэлийн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн төслийг салбарын гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийг үргэлжлүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байхаар боловсруулав.

Улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдсэнтэй холбоотойгоор Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан улсын төсвөөс хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэл болон тусламж, үйлчилгээний зардал нэмэгдэхээр байна.

Эрүүл мэндийн сангаас зарцуулах тусламж, үйлчилгээний санхүүжилтийг анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, бүс нутгийн онцлогийг харгалзсан ялгаатай байдлаар сумын эрүүл мэндийн төвийн эмнэлгүүдэд олгох, нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд түлхүү анхаарахад чиглүүллээ.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн нийт орлогыг 2,551.8 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн. Үүний 1,312.8 тэрбум төгрөгийг төр хариуцах эмнэлгийн тусламж, үйлчилгээ, төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцан төлөх даатгуулагчдын шимтгэлийн орлого, 1,239.0 тэрбум төгрөг нь ажил олгогч, даатгуулагчийн болон бусад даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлогоос тус тус бүрдэхээр байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн нийт зарлагыг 2,273.3 тэрбум төгрөг байхаар төлөвлөлөө. Үүнээс эрүүл мэндийн байгууллагад олгох тусламж, үйлчилгээний санхүүжилтийг 2,090.0 тэрбум төгрөг, төр хариуцах эмийн зардлын хяналт, хүртээмжийг сайжруулах зорилгоор эмийн үнийн хөнгөлөлтөд олгох санхүүжилтийг 169.8 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардлыг 13.5 тэрбум төгрөг байхаар тус тус тооцлоо.

Тус сангийн эргэн төлөх төлбөрийн хэмжээг 75.5 тэрбум төгрөг байхаар төлөвлөв.

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЙЛБАР /зүйл тус бүрээр/

1 дүгээр зүйл: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн зорилтыг тусгасан.

2 дугаар зүйл: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуультай хамааралтай бусад хууль тогтоомжийг тусгасан.

3 дугаар зүйл: Эрүүл мэндийн даатгалын санд 2026 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлогын хэмжээг хүснэгтээр тусгасан.

4 дүгээр зүйл: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн жилд эргэн төлөх төлбөрийн хэмжээг тусгасан.

5 дугаар зүйл: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн зарлагын хэмжээг хүснэгтээр тусгасан.

6 дугаар зүйл: Хуулийг мөрдөж эхлэх огноог тусгасан.

---oOo---